


Нэг удаагийн импорт, экспортын лиценз олгогдсон байдал, 2021 онд

2021 онд нэг удаагийн импорт, экспортын лицензийн (Монгол улсын хилээр нэвтрэх бүтээгдэхүүний ачилт тус бүрд дагалдах баримт бичиг) 9994 хүсэлт хүлээн авч, 86%-ийг нь буюу 365 байгууллагад 9574 лицензийг батлагдсан журмын дагуу ажлын 3-5 хоногт багтаан олгож, шуурхай шийдвэрлэж ажилласан байна. Лиценз олгоогүй хүсэлт буюу 4.2% нь барааны дагалдах бичиг баримтын бүрдэл болон үйлдвэрлэгчийн мэдээлэл хангалтгүй, чанар, аюулгүй байдлын баталгаа, нотолгоот мэдээлэл ирүүлээгүй, Монгол улсад хэрэглэх зөвшөөрөлд бүртгэгдээгүй зэрэг юм.



Импорт, экспортын лиценз хүссэн 365 байгууллагын 8.7% буюу 32 байгууллагад илэрсэн зөрчлийг бүртгэж, лиценз олгохоос татгалзан, алдаа зөрчлийг залруулж мэдээний сан үүсгэн, цаашид үйл ажиллагаандаа анхаарч ажиллах шаардлагатай талаар холбогдох байгууллагуудад мэдээлж ажилласан.

Нийтлэг илрэх зөрчлийн байдлыг түүвэрлэн нэгтгэн харуулахад:

№	Зөрчлийн мэдээлэл	Тайлбар
1	Бүтээгдэхүүний нэр зөрүүтэй	Барааны нэр, төрөл алдаатай мэдүүлэх
2	Бүтээгдэхүүний тоо хэмжээ зөрүүтэй.	Эмийн дээжинд зөвшөөрөгдөх хэмжээнээс хэт ихээр мэдүүлэх
3	Жишээ нь 140-г гэх 14 гэх эсвэл бараа дутуу бичих	Барааны тоо, хэмжээг дутуу мэдүүлэх
4		Нэхэмжлэх дээрхи тоо хэмжээнээс ачилт нь зөрүүтэй байх
5	Мэдээллээ өөрчлөх	Үйлдвэрлэгчийн болон барааны мэдээллийг буруу эсвэл дутуу бичих

6	Савлалтын хэлбэр өөрчлөх	Савлагааны тоо, хэлбэрийг зөрүүтэй мэдүүлэх.
7	Эмийн тун өөрчлөх	Тунгийн хэмжээ, хэлбэрийг зрүүтэй мэдүүлэх.
8	ISO, EC гэрчилгээгүй	Чанар, стандартын гэрчилгээ дутуу, эсвэл хугацаа дууссан байх
9	Үнэ буруу мэдүүлэх	Гэрээний үнэ, инвойсын үнээс зөрүүтэй байх, үнийг өөрчилж мэдүүлэх
10	Нэхэмжлэх, гэрээний мэдээлэл өөрчлөх	Мэдээллийг дутуу ирүүлэх, өөрчилж мэдүүлэх, хуурамч гэрээ
11	Лиценз олгох боломжгүй хүсэлт	Тусгай зөвшөөрөл эсвэл улсын бүртгэлийн гэрчилгээгүй байх
12	Бичиг баримт хангалтгүй	Дагалдах материал бүрэн бус, хуурамч, баталгаат бус байх
13	Гэрээний нөхцөл зөрчих	Бусад байгууллагын онцгой эрхтэй бүтээгдэхүүнийг импортлох